



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА
ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Ховд аймгийн Буянт сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ХОА-2023/97/НА/-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Ховд хот
2023 он

Тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар
Утас: 70433061
Цахим хаяг: Boldbaatar.Kh @audit.gov.mn
Аудитын менежер: А.Цэцэгсүрэн
Утас:70432545
Цахим хаяг: tsetsegsuren.a@audit.gov.mn
Гэрэлт Хөхийн тэнцвэр Аудит ХХК-ны Ховд дахь салбар
Аудитор: Д.Хишгээ
Утас: 70432545
цахим хаяг: hishgee.da @ gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	2
Асуудлыг онцолсон хэсэг	3
Аудитын гол асуудал	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН	4
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	9
4. АУДИТЫН ТАЙЛАН
4.1 Ерөнхий зүйл	Error! Bookmark not defined.
4.2 Материаллаг байдал.....	Error! Bookmark not defined.
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт ...	Error! Bookmark not defined.
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	Error! Bookmark not defined.
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	Error! Bookmark not defined.
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	Error! Bookmark not defined.
4.5.1 Завсрын аудитын талаар	Error! Bookmark not defined.
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй.	Error! Bookmark not defined.
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	Error! Bookmark not defined.
5.1 Төлбөрийн акт	13
5.2 Албан шаардлага:	13
5.3 Зөвлөмж.....	Error! Bookmark not defined.
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	Error! Bookmark not defined.

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
СТА	Санхүүгийн Тайлангийн Аудит
НА	Нотлох Ажил
ТШЗ	Төсвийн Шууд Захирагч



2023.02.20 № 2/65
танай _____-ны № _____-г

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Ховд аймгийн Буянт сумын хүүхдийн цэцэрлэгийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэхбайгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Боловсролын салбар төсвийн шинэчлэлийн хүрээнд сургуулийн санхүүгийн эрх мэдэл, хувьсах зардал, сургуулийн бүтэц, хэв шинжийн шинэчлэл, сургалтын чанарт суурилсан цалин урамшууллын тогтолцоог бий болгосон байна.

Багш нарын цалинг ТҮ-5 ангиллаар олгосон, хувьсах зардлын тухайд багшийн эрүүл мэндийн үйлчилгээ, дата хэрэглээний зардал, хичээл практикийн зардал, багшийн мэргэжлийн тасралтгүй хөгжлийн зардлыг тусгаж, төлөвлөх, зарцуулах аргачлалыг Засгийн газрын 2022 оны 91 дугаар тогтоолоор баталж мөрдсөн байна.

Сангийн яамны 2022 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 18 дугаартай чиглэлийн дагуу мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 1,17 сая төгрөгийг улсын төсөвт татан төвлөрүүлээгүй байна.

Аудитын гол асуудал

АДБОУС 2701.8-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх ажил гүйлгээ байхгүй болно.

Засгийн Газрын 2022 оны 91 дүгээр тогтоолоор хувьсах зардлын нормативын хэмжээг шинэчлэн тогтоосон. Боловсрол Шинжлэх ухааны сайдын 2022 оны А/500 дугаар тушаалаар сургуулийн үйл ажиллагааны гүйцэтгэлийн чанар, үр дүнг үнэлж, үр дүнгийн нэмэгдэл урамшуулалыг 5 багшд 10 хувиар олгосон байна.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны 12 дугаар сарын 06 -ны өдрийн А/192 дугаар тушаалын хавсралтын дагуу илүү цагийн хөлсийг олгохдоо дундаж цалин хөлс тооцох журмыг баримтлаагүй байна.

Бусад асуудлын хэсэг

Тус цэцэрлэг 2022 онд хамран сургах тойргийн 150 хүүхэдтэй, үүнээс үндсэн бүлэгт 125 хүүхэд хувилбарт сургалтанд 48 хүүхэд хамрагдсан бөгөөд нийт 176 хүүхэд хамрагдаж хамран сургалт 115,3 хувьтай байна.

7 бүлэг 35 заалт бүхий ажлын гүйцэтгэлийн төлөвлөгөөг Засаг даргаар баталгаажуулж үр дүнг тооцож, 98 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжүүлэн ажилласан

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Х.БОЙДБААТАР



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>33,971,017.00</u>	<u>33,991,667.13</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	-	1,175,935.32
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	-	1,175,935.32
3121	Төгрөг	-	1,175,935.32
31211	Төрийн сангийн харилцах	-	1,175,935.32
33	АВЛАГА	-	10,199.81
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	-	10,000.00
335	Бусад авлага	-	199.81
3351	Байгууллагаас авах авлага	-	199.81
35	БАРАА МАТЕРИАЛ	33,971,017.00	32,805,532.00
354	Хангамжийн материал	33,971,017.00	32,805,532.00
35420	Аж ахуйн материал	11,491,890.00	13,932,740.00
35440	Түлш, шатах тослох материал	2,203,000.00	2,673,000.00
35460	Хүнсний материал	15,582,750.00	11,506,415.00
35470	Бусад хангамжийн материал	4,693,377.00	4,693,377.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>637,721,387.83</u>	<u>611,596,245.28</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	637,721,387.83	611,596,245.28
392	Биет хөрөнгө	622,052,287.87	596,155,645.28
39201	Барилга, байгууламж, орон сууц	661,378,312.38	661,378,312.38
39202	Хуримтлагдсан элэгдэл	(78,485,141.07)	(100,000,556.55)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	67,055,205.00	67,908,105.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(56,059,005.71)	(58,655,750.85)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	53,317,574.50	53,317,574.50
39208	Хуримтлагдсан элэгдэл	(27,154,657.23)	(29,792,039.20)
39217	Ном	2,000,000.00	2,000,000.00
393	Биет бус хөрөнгө	15,669,099.96	15,440,600.00
39301	Програм хангамж	649,500.00	649,500.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(421,000.04)	(649,500.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	15,440,600.00	15,440,600.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>671,692,404.83</u>	<u>645,587,912.41</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>130,000.00</u>	<u>1,821,500.00</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	130,000.00	1,821,500.00
413	Өглөг	130,000.00	1,821,500.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	130,000.00	1,793,500.00
4136	Бусад өглөг	-	28,000.00
41361	Байгууллагад төлөх өглөг	-	28,000.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>48,386,927.83</u>	<u>20,590,935.41</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	48,386,927.83	20,590,935.41
512	Хуримтлагдсан үр дүн	(245,360,615.15)	(273,156,607.57)
51210	Өмнөх үеийн үр дүн	(245,360,615.15)	(245,360,615.15)
51220	Тайлант үеийн үр дүн	-	(27,795,992.42)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	293,747,542.98	293,747,542.98
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>48,516,927.83</u>	<u>22,412,435.41</u>

2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	326,658,276.0	375,436,400.0
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	73,600.0	2,275,000.0
120	Нийтлэг татварын бус орлого	-	1,152,800.0
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	1,152,800.0
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	-	1,152,800.0
122	Тусламжийн орлого	73,600.0	1,122,200.0
122001	Хандив тусламж /дотоод/	73,600.0	1,122,200.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	326,584,676.0	373,161,400.0
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	311,841,200.0	332,169,300.0
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	7,853,400.0	332,169,300.0
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	303,987,800.0	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	517,238.0	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	517,238.0	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	13,877,500.0	40,992,100.0
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	13,877,500.0	40,992,100.0
1330	Төсвийн захирагчдаас	348,738.0	-
133004	Төсвийн ерөнхийлөн захирагчаас олгосон санхүүжилт	348,738.0	-
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	341,325,253.2	403,232,392.4
21	УРСГАЛ ЗАРДАЛ	341,325,253.2	403,232,392.4
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	326,183,189.2	403,232,390.1
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	227,783,554.0	272,548,554.9
210101	Үндсэн цалин	137,087,000.0	199,446,143.6
210102	Нэмэгдэл	76,185,254.0	58,138,724.9
210104	Урамшуулал	14,511,300.0	14,963,686.4
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	30,879,756.0	34,224,377.5
210201	Тэтгэврийн даатгал	21,745,556.0	23,706,964.2
210202	Тэтгэмжийн даатгал	2,278,500.0	2,749,154.5
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,822,900.0	2,204,363.8
210204	Ажилгүйдлийн даатгал	455,700.0	483,740.9
210205	Эрүүл мэндийн даатгал	4,577,100.0	5,080,154.1
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	11,939,060.0	20,688,080.2
210301	Гэрэл, цахилгаан	2,106,711.4	5,123,080.2
210302	Түлш, халаалт	9,432,348.6	15,565,000.0
210303	Цэвэр, бохир ус	400,000.0	-
2104	Хангамж, бараа материалын зардал	3,979,700.0	2,340,300.0
210401	Бичиг хэрэг	1,604,200.0	1,484,300.0
210402	Тээвэр, шагахуун	389,300.0	840,000.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	85,600.0	-
210404	Ном, хэвлэл	59,600.0	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	668,500.0	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,172,500.0	-
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	-	16,000.0
2105	Нормативт зардал	16,880,860.0	38,820,755.0
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	647,500.0	50,000.0
210502	Хоол, хүнс	15,250,360.0	38,770,755.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	983,000.0	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,467,600.0	814,000.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,143,600.0	-
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	324,000.0	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	814,000.0

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	32,252,659.2	33,796,322.6
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	4,699,280.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн даллага хийх	3,922,600.0	2,119,000.0
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	28,330,059.2	26,978,042.6
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	15,142,064.0	2.3
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	15,077,724.0	2.3
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	15,077,724.0	2.3
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	64,340.0	-
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	64,340.0	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(14,666,977.2)	(27,795,992.4)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(14,666,977.2)	(27,795,992.4)

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	623,175,477.0	293,747,543.0	(226,404,560.0)	690,518,460.0
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	623,175,477.0	293,747,543.0	(226,404,560.0)	690,518,460.0
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	(18,956,055.2)	(18,956,055.2)
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	623,175,477.0	293,747,543.0	(245,360,615.2)	671,562,404.8
D01	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	623,175,477.0	293,747,543.0	(245,360,615.2)	671,562,404.8
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	623,175,477.0	293,747,543.0	(245,360,615.2)	671,562,404.8
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	(27,795,992.4)	(27,795,992.4)
D09	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	623,175,477.0	293,747,543.0	(273,156,607.6)	643,766,412.4

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	326584676.0	373161400.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	326584676.0	373161400.0
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	311841200.0	332169300.0
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	7853400.0	332169300.0
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	303987800.0	0.0
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	517238.0	0.0
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	517238.0	0.0
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	13877500.0	40992100.0
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	13877500.0	40992100.0
1330	Төсвийн захирагчдаас	348738.0	0.0
133004	Төсвийн ерөнхийлөн захирагчаас олгосон санхүүжилт	348738.0	0.0
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	316522538.0	371402464.7
21	УРСГАЛ ЗАРДАЛ	316522538.0	371402464.7

210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	301380474.0	371402462.4
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	227783554.0	272629010.7
210101	Үндсэн цалин	137087000.0	199562654.3
210102	Нэмэгдэл	76185254.0	58102670.0
210104	Урамшуулал	14511300.0	14963686.4
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	30760500.0	33790821.7
210201	Тэтгэврийн даатгал	21646300.0	23281653.9
210202	Тэтгэмжийн даатгал	2278500.0	2689115.4
210203	ҮОМШӨ-ний даатгал	1822900.0	2134215.5
210204	Ажилгүйдлийн даатгал	455700.0	1029771.9
210205	Эрүүл мэндийн даатгал	4557100.0	4656065.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	13653160.0	17399500.0
210301	Гэрэл, цахилгаан	2106711.4	2117500.0
210302	Түлш, халаалт	11146448.6	14882000.0
210303	Цэвэр, бохир ус	400000.0	400000.0
2104	Хангамж, бараа материалын зардал	2847738.0	0.0
210401	Бичиг хэрэг	1604200.0	0.0
210402	Тээвэр, шатахуун	391400.0	0.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	85600.0	0.0
210404	Ном, хэвлэл	59600.0	0.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	517238.0	0.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	189700.0	0.0
2105	Нормативт зардал	18864560.0	35840000.0
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	62800.0	0.0
210502	Хоол, хүнс	18207660.0	35840000.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	594100.0	0.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	160000.0	160000.0
210604	Урсгал засвар	160000.0	160000.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2467600.0	814000.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2143600.0	0.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	324000.0	0.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	0.0	814000.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	4843362.0	10769130.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	0.0	7769130.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4843362.0	3000000.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	15142064.0	2.3
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	15077724.0	2.3
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	15077724.0	2.3
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	64340.0	0.0
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	64340.0	0.0
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	10062138.0	1758935.3
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	1860000.0	583000.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1860000.0	583000.0
2200	Дотоод эх үүсвэрээр	1860000.0	583000.0
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	1860000.0	583000.0
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-1860000.0	-583000.0
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	0.0	0.0
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	8202138.0	1175935.3

9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		0.0
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.0	1175935.3

2.5 Төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	373,161,400.0	371,985,462.4
21	УРСГАЛ ЗАРДАЛ	373,161,400.0	371,985,462.4
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	373,161,400.0	371,985,462.4
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	273,192,400.0	272,629,010.7
210101	Үндсэн цалин	182,024,200.0	199,562,654.3
210102	Нэмэгдэл	76,256,900.0	58,102,670.0
210103	Унаа хоолны хөнгөлөлт		
210104	Урамшуулал	14,911,300.0	14,963,686.4
210105	Гэрээт ажлын хөлс		
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	34,149,300.0	33,790,821.7
210201	Тэтгэврийн даатгал	25,035,100.0	23,281,653.9
210202	Тэтгэмжийн даатгал	2,278,500.0	2,689,115.4
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,822,900.0	2,134,215.5
210204	Ажилгүйдлийн даатгал	455,700.0	1,029,771.9
210205	Эрүүл мэндийн даатгал	4,557,100.0	4,656,065.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	17,399,500.0	17,399,500.0
210301	Гэрэл, цахилгаан	2,117,500.0	2,117,500.0
210302	Түлш, халаалт	14,882,000.0	14,882,000.0
210303	Цэвэр, бохир ус	400,000.0	400,000.0
2105	Нормативт зардал	35,840,000.0	35,840,000.0
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	62,800.0	
210502	Хоол, хүнс	35,182,400.0	35,840,000.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	594,800.0	
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	160,000.0
210604	Урсгал засвар		160,000.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	814,000.0	814,000.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	814,000.0	814,000.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	11,766,200.0	11,352,130.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	8,766,200.0	8,352,130.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,000,000.0	3,000,000.0
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	373,161,400.0	373,161,397.7
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	332,169,300.0	332,169,300.0
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	332,169,300.0	332,169,300.0
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	40,992,100.0	40,992,097.7
132001	Орон нутгийн төсвөөс	40,992,100.0	40,992,097.7
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		1,175,935.3

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Буянт сумын Хүүхдийн цэцэрлэг Хүүхдийн нийгэм сэтгэл зүй танин мэдэхүйн хөгжлийг дэмжих, боловсрол эзэмшихэд тулгарч буй бэрхшээлийг арилгаж, сурах тэгш боломж бүрдүүлэх, сургалт үйл ажиллагааг чанар үр дүнтэй зохион байгуулах, хамтран суралцах арга

барилыг сургалтад нэвтрүүлэх үндсэн зорилготойгоор 5 бүлэг 22 орон тоотойгоор үндсэн сургалтаар 150 хүүхэд, хувилбарт сургалтад 64 хүүхэд хамрагдсан байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллага нь үйл ажиллагаандаа СӨБ-ийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Татварын тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хуулийг мөрдөн ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Тухайлбал:

- “Хувьсах зардлын дундаж норматив тогтоох тухай” Засгийн газрын 2022 оны 91 дүгээр тогтоол;
- “Хичээл, сургалтын үйл ажиллагаа, Багшийн тасралтгүй хөгжил, цахим хэрэглээ, тоног төхөөрөмж нөхөн хангалт батлах тухай” Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2022 оны А/170 дугаар тушаал;
- “Ерөнхий боловсролын сургуульд кабинет, лаборатори, цахим сургалтын танхим байгуулах, ашиглах тухай журам” Боловсрол, шинжлэх ухааны сайдын А/465 дугаар тушаал;
- “Төрийн болон орон нутгийн өмчийн сургууль, цэцэрлэгийн үйл ажиллагааны гүйцэтгэлийн чанар үр дүн үнэлж, үр дүнгийн урамшуулал олгох журам” Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2022 оны А/500 дугаар тушаал тус тус шинэчлэгдэн баталсан байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын ажилтан томилсон, дотоод хяналтын баг өдөр тутмын үйл ажиллагаандаа хяналт хэрэгжүүлж ажилладаг байна. Иймд дотоод хяналтын хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж дүгнэлээ.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Тус цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж буй Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг 2013 онд баталсан бөгөөд шинээр батлагдсан холбогдох хууль, дүрэм, журам, заавар аргачлалын дагуу өөрчлөлтийг тусгасан байгаа нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Буянт сумын хүүхдийн цэцэрлэг 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 26.03 сая төгрөгөөр буюу 3.8 хувиар буурсан байна. Өмнөх оноос мөнгөн хөрөнгө, бараа материал, үндсэн хөрөнгө, засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэлд өөрчлөлт орсон байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө		1.17	-1.17
Авлага			0
Бараа материал	33.9	32.8	1.1
Үндсэн хөрөнгө	637.7	611.6	26.1
Нийт хөрөнгө	671.6	645.57	26.03
Өр төлбөр		1.77	-1.77
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	671.6	643.8	27.8
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	671.6	645.57	26.03

Дансны үлдэгдэлд гарсан дараах өөрчлөлтүүд байна. Үүнд:

- ✓ Сангийн яамны 2022 оны 12 дугаар сарын 25 өдрийн 18 тоот албан бичгээр хүргүүлсэн чиглэлийн дагуу мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 1.17 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.
- ✓ Тайлант онд төсвийн хөрөнгөөр 0,8 сая төгрөгийн тоног төхөөрөмж худалдан авсан

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллага 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 332,2 сая төгрөг, орон нутгийн төсвөөс 40,9 сая төгрөг нийт зарлагыг 373,1 сая төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Боловсролын салбар нь үр дүн гүйцэтгэлд суурилсан төсвөөр төсвөө боловсруулснаар цалингийн зардлыг 33,9 сая төгрөгөөр, бусад урсгал зардлыг 8,2 сая төгрөгөөр өсгөж баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 9 хөтөлбөрийн 15 арга хэмжээг санхүүжүүлэхээр 332.2 сая төгрөгийг улсын төсвөөс, 40.9 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс бүрдүүлэхээр баталжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 332.2 сая төгрөг, орон нутгийн төсвөөс 40.9 сая төгрөг нийт 373.2 сая төгрөгийн санхүүжилтийг бүрдүүлж, орон нутгийн төсөвт 2 төгрөг 30 мөнгө төгрөгийг төвлөрүүлэн, 1.17 сая төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 371.9 сая төгрөг буюу 99.6 хувьтай байгаа нь багш ажилчдын мэргэжил дээшлүүлэх 0.17, боловсролын стандарт, сургалтын төлөвлөгөө, хөтөлбөр 1.0 төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/сая төгрөг/

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
71801-80111	Барилгын тогтмол зардал	17.6	17.6		100
71801-80112	Нийтлэг үйлчилгээ	23.4	23.4		100
71801-81605	Эрүүл мэндийг дэмжих	1.1	1.1		100
71801-81807	Хүүхдийн хоол	35.8	35.8		100
71801-81816	Зөв монгол хүүхэд үндэсний хөтөлбөр	1.1	1.1		100

71801-81823	Багш ажилчдын мэргэжил дээшлүүлэх	1.1	0.93	0.17	118
71801-81834	Боловсролын стандарт, сургалтын төлөвлөгөө, хөтөлбөр	259.1	258.1	1	100
71801-81835	Сургалтын хэвийн үйл ажиллагааг хангах	33.9	33.9		100
	Дүн	373.10	371.93	1.17	100

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Ховд аймгийн Буянт сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Гэрэлт Хөхийн тэнцвэр аудит ХХК-ны Ховд дахь салбарын аудитор Д.Хишгээ гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер А.Цэцэгсүрэн, дарга, тэргүүлэх аудитор Х.Болдбаатар нар хэрэгжүүлсэн.

Ховд аймгийн Буянт сумын сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 02 дүгээр сарын 03 -ны өдрийн А/01 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны нийт зардлын 283,6 сая төгрөгөөс 2 хувиар буюу 5,6 сая төгрөгөөр тогтоосон. Гүйцэтгэлийн шатанд 2022 оны санхүүгийн тайлангийн нийт 375,4 сая төгрөгөөр 2 хувиар буюу 7,5 сая төгрөгөөр тогтоож, гүйцэтгэлийн материаллаг байдлыг 80 хувиар тооцон 6,0 сая төгрөгөөр дахин хянаж шинэчлэн тогтоосон болно.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Аудитаар төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой 6 горим сорил хэрэгжүүлсний үр дүнд илэрсэн зөрчлийн дэлгэрэнгүйг тайлангийн 5-д дэлгэрэнгүй оруулсан.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим системд тендерт шалгарсан оролцогчийн мэдээлэл, таван саяас дээш орлого, зарлагын гүйлгээг бүрэн мэдээлж, 72 тушаал шийдвэрээс 71-ийг хугацаандаа мэдээлж, 1 мэдээлэлийг хугацаа хоцорч мэдээлсэн байна. Хуулийн хэрэгжилт 100.0 хувьтай байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

210502 хоолны зардлаас гэрэл цахилгааны зардал 2445.8 мянган төгрөгийн төлсөн нь Хангамжийн материалын зардлын төсвийг энэ онд бүгдийг бараа үйлчилгээний бусад зардал дансанд бүртгэж тайлагнасан нь Сангийн сайдын Зардлын эдийн засгийн ангилал батлах тухай 2021-10-29-ны 190 тоот тушаалтай нийцээгүй байна.

4.5 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар “Зөрчилгүй” санал дүгнэлт авч акт, албан шаардлага өгөгдөөгүй, 7.6 сая төгрөгийн 1 зөвлөмжийг бүрэн биелүүлж ажилласан байна.

Хүснэгт 3. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагын хэрэгжилт

/ Сая төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт					
Албан шаардлага					
Зөвлөмж	1	7.6	1	7.6	100

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг, оны эцэст салбарын зохион байгуулдаг худалдан авах ажиллагаа, хөрөнгө оруулалтаар ирсэн хөрөнгийн хэрэгцээ шаардлагыг анхаарч үзэх шаардлагатай гэж үзлээ.

5. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 3,4 сая төгрөгийн зөрчил¹, илэрснээс 1,0 сая төгрөгний акт, 2,4 сая төгрөгний дахин давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өглөө.

Төлбөрийн акт:

2020 оны 9-р сард иргэн Л. Гантөмөр, Л.Одгариг нараас нэг бүрийн үнэ 600 төгрөгөөр 3000 кг төмс, 2000 кг лууван худалдан авч нөөцөлсөн байна.

Тус байгууллага 2021-2022 онд ковид-19 цар тахалаас шалтгаалан ажиллаагүй бөгөөд нөөцөлсөн төмс, луувангаа зарцуулж чадаагүйн улмаас орон нутгийн зах зээлийн ханшаар төмс, лууван кг нь 1800 төгрөг болж 2020 онд худалдан авсан үнээсээ 3 дахин нэмэгдсэн байна. 2023 оны 2-р сарын байдлаар нэг кг-ийг 600 төгрөгөөр худалдан авсан төмс 1200 кг, лууван 621 кг –ийн үлдэгдэлтэй байгаа бөгөөд 2021-2022 онд нийт 1800 кг төмс, 1379 кг лууван зарцуулжээ. Тус цэцэрлэгийн эрхлэгчийн хүсэлтээр үлдэгдэл 1200*600 -- 720000, 621*600 -372600 бүгд **1092600** төгрөгний төмс, луувангийн үнийг тухайн байгууллагын төсөвт оруулах акт бичлээ.

5.3 Зөвлөмж

5.3.1 Төсвийн гүйцэтгэлийн зардалтай холбоотой

¹Тайлагнасан санхүүгийн тайлангийн үзүүлэлт, тайлагнасан байвал зохих үзүүлэлтийн хоорондын зөрүү. Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруутусганилэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруутайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

Илрүүлэлт:210502 хоолны зардлаас гэрэл цахилгааны зардал 2445.8 мянган төгрөгийн төлсөн нь Хангамжийн материалын зардлын төсвийг энэ онд бүгдийг бараа үйлчилгээний бусад зардал дансанд бүртгэж тайлагнасан нь Сангийн сайдын Зардлын эдийн засгийн ангилал батлах тухай 2021-10-29-ны 190 тоот тушаалтай нийцээгүй байна.

Өгсөн зөвлөмж :Зардлын зүйл анги зөрчин батлагдсан төсвийг зориулалтын бус зүйлд зарцуулсан зөрчил дутагдлыг дахин давтан гаргахгүй байх

5.3.2. Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал

Тус цэцэрлэг оны эцэст тэг үлдэгдэлтэй 100 ш 78.8 сая төгрөгний үндсэн хөрөнгө байгаа нь Төсвийн тухай хуулийн 14.2.3-т "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах"; 16.5.4-т "төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31.1-т "Төрийн өмчит хуулийн этгээд эзэмшилдээ байгаа илүүдэл үндсэн эд хөрөнгө, түүнчлэн ашиглах хугацаа нь дууссан буюу эсхүл осол гэмтэлд өртсөний улмаас зориулалтаар нь ашиглах боломжгүй болсон бөгөөд засаж, сэлбэж ашиглах нь эдийн засгийн хувьд үр ашиггүй нь тооцоогоор нотлогдсон эд хөрөнгийг худалдаж, шилжүүлж, акт тогтоон устгаж болно." зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Хөрөнгийн ангилал буруу хийгдэж тайлагнаад байгаа өөрийн эзэмшилд байгаа илүүдэл бараа материал , үндсэн эд хөрөнгө, ашиглах хугацаа нь дууссан дээрх хөрөнгийг ашиглах боломжтой хөрөнгийг дахин үнэлж ашиглах, ашиглах боломжгүй хөрөнгийг акталж устгаж эдийн засгийн хувьд үр ашигтай байхаар шийдвэрлэх

6. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс			
			Төлбөрийн акт		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
2020 онд нэг кг 600 төгрөгөөр нөөцөлсөн төмс , луув нэгн кг үнэ 1800 төгрөг болж 1 кг -ийг 600 төгрөгөөр нийлүүлэх боломжгүй болсоны үнийн зөрүү	1	1092.6	1	1092.6		
210502 хоолны зардлаас гэрэл цахилгааны зардал 2445.8 мянган төгрөгийн төлсөн	1	2,445.8			1	2,445.8
Тус цэцэрлэгийн үндсэн хөрөнгийн 100 ш 78.8 сая төгрөгний үндсэн хөрөнгө байна.						
Зөрчлийн дүн	2	3538.4	1	1092.6	1	2445.8

АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:

Х.БОЛДБААТАР

АУДИТЫН МЕНЕЖЕР:

А.ЦЭЦЭГСҮРЭН

ТАЙЛАНГ БИЧСЭН: АУДИТОР:

Д.ХИШГЭЭ

720000, 621*600 -372600 бүгд 1092600 төгрөгний төмс , луувангийн үнийг тухайн байгууллагын төсөвт оруулах акт бичлээ.

5.3 Зөвлөмж

5.3.1 Төсвийн гүйцэтгэлийн зардалтай холбоотой

Илрүүлэлт: 210502 хоолны зардлаас гэрэл цахилгааны зардал 2445.8 мянган төгрөгийн төлсөн нь Хангамжийн материалын зардлын төсвийг энэ онд бүгдийг бараа үйлчилгээний бусад зардал дансанд бүртгэж тайлагнасан нь Сангийн сайдын Зардлын эдийн засгийн ангилал батлах тухай 2021-10-29-ны 190 тоот тушаалтай нийцээгүй байна.

Өгсөн зөвлөмж: Зардлын зүйл анги зөрчин батлагдсан төсвийг зориулалтын бус зүйлд зарцуулсан зөрчил дутагдлыг дахин давтан гаргахгүй байх

5.3.2. Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал

Тус цэцэрлэг оны эцэст тэг үлдэгдэлтэй 100 ш 78.8 сая төгрөгний үндсэн хөрөнгө байгаа нь Төсвийн тухай хуулийн 14.2.3-т "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах"; 16.5.4-т "төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31.1-т "Төрийн өмчит хуулийн этгээд эзэмшилдээ байгаа илүүдэл үндсэн эд хөрөнгө, түүнчлэн ашиглах хугацаа нь дууссан буюу эсхүл осол гэмтэлд өртсөний улмаас зориулалтаар нь ашиглах боломжгүй болсон бөгөөд засаж, сэлбэж ашиглах нь эдийн засгийн хувьд үр ашиггүй нь тооцоогоор нотлогдсон эд хөрөнгийг худалдаж, шилжүүлж, акт тогтоон устгаж болно." зөрчсөн байна.


Өгсөн зөвлөмж: Хөрөнгийн ангилал буруу хийгдэж тайлагнаад байгаа өөрийн эзэмшилд байгаа илүүдэл бараа материал , үндсэн эд хөрөнгө, ашиглах хугацаа нь дууссан дээрх хөрөнгийг ашиглах боломжтой хөрөнгийг дахин үнэлж ашиглах, ашиглах боломжгүй хөрөнгийг акталж устгаж эдийн засгийн хувьд үр ашигтай байхаар шийдвэрлэх

6. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Үүнээс					
	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
2020 онд нэг кг 600 төгрөгөөр нөөцөлсөн төмс , луув нэгн кг үнэ 1800 төгрөг болж 1 кг -ийг 600 төгрөгөөр нийлүүлэх боломжгүй болсоны үнийн зөрүү	1	1092.6	1	1092.6		
210502 хоолны зардлаас гэрэл цахилгааны зардал 2445.8 мянган төгрөгийн төлсөн	1	2,445.8			1	2,445.8
Тус цэцэрлэгийн үндсэн хөрөнгийн 100 ш 78.8 сая төгрөгний үндсэн хөрөнгө байна.						
Зөрчлийн дүн	2	3538.4	1	1092.6	1	2445.8

АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:  Ж.БОЛДБААТАР

АУДИТЫН МЕНЕЖЕР:  А.ЦЭЦЭГСҮРЭН

ТАЙЛАНГ БИЧСЭН: АУДИТОР:  Д.ХИШГЭЭ